

**Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилчдад
зориулсан СПАЙКВАКС (СПАЙК-вакс гэж
дууддаг) (КОВИД-19 вакцин, мРНХ) вакцины
(2023-2024 томьёо)
мэдээлэл**

СПАЙКВАКС вакциныг хийлгэхээс өмнө энэ мэдээллийн хуудсыг уншина уу. Энэхүү хураангуй нь таныг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцах боломжийг хязгаарлахгүй болно. Хэрэв танд асууж лавлах зүйл байвал эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцана уу.

СПАЙКВАКС гэж юу вэ?

СПАЙКВАКС нь таныг COVID-19-өөс хамгаалах вакцин юм. СПАЙКВАКС нь 12 ба түүнээс дээш насны хүмүүст зориулагдсан. СПАЙКВАКС-ийн вакцинжуулалт нь вакцин хийлгэсэн бүх хүмүүсийг хамгаалахгүй байж магадгүй юм.

СПАЙКВАКС вакцин нь КОВИД-19 үүсгэгч SARS-CoV-2 вирус агуулаагүй. СПАЙКВАКС вакцин танд КОВИД-19 халдаах боломжгүй.

Хэн СПАЙКВАКС хийлгэх ёсгүй вэ?

Та дараах тохиолдолд СПАЙКВАКС вакцинд хамрагдаж болохгүй:

- СПАЙКВАКС, Модерна КОВИД-19 вакцин (анхны моновалент), Модерна КОВИД-19, Бивалент вакцины өмнөх тунг хийлгэсний дараа харшлын хүнд урвал илэрсэн¹
- энэ вакцины аливаа бүрэлдэхүүн хэсэгт хүчтэй харшлын урвал илэрсэн (**СПАЙКВАКС ямар найрлагатай вэ?** хэсгийг үзнэ үү)

Би эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдээ юу хэлэх ёстой вэ?

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдээ дараах зүйлсийг оролцуулан эрүүл мэндийн байдлынхаа талаар мэдэгдэнэ үү:

- ямар нэгэн харшилтай эсэх
- КОВИД-19 вакцины өмнөх тунг хийлгэсний дараа хүнд хэлбэрийн харшлын урвал илэрсэн
- өмнө нь миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардит (зүрхний гаднах бүрхүүлийн үрэвсэл) зэрэг өвчнөөр өвдөж байсан эсэх
- халуурч байгаа эсэх
- цус алдалтын эмгэгтэй эсвэл цус шингэлэгч эм хэрэглэдэг
- дархлаа суларсан эсвэл таны дархлааны тогтолцоог өөрчлөх эм хэрэглэдэг
- жирэмсэн эсвэл жирэмслэх төлөвлөгөөтэй
- хөхүүл
- өөр ямар нэгэн КОВИД-19-ийн вакцин хийлгэсэн
- тарилгаас шалтгаалан ухаан алдаж байсан

СПАЙКВАКС вакциныг хэрхэн тарьдаг вэ?

СПАЙКВАКС вакциныг булчинд тарилга хэлбэрээр хийнэ.

СПАЙКВАКС вакцин ямар эрсдэлтэй вэ?

СПАЙКВАКС вакцин хийлгэсэн зарим хүмүүст хүнд хэлбэрийн харшлын урвал илэрч,

¹СПАЙКВАКС вакциныг Модерна КОВИД-19 вакцин (анхны моновалент) болон Модерна КОВИД-19, Бивалент вакцинтай адил аргаар хийдэг боловч SARS-CoV-2 Омикрон хувилбарын ХВВ.1.5 баяжуулалтын уургийг кодогдог (Омикрон ХВВ.1.5).

Модерна КОВИД-19 вакцин (анхны моновалент) болон Модерна КОВИД-19, Бивалент вакцин. СПАЙКВАКС вакцин хүнд хэлбэрийн харшлын урвал үүсгэх маш бага магадлалтай. Хүнд хэлбэрийн харшлын урвал нь СПАЙКВАКС вакцины нэг тун хийлгэсний дараа хэдэн минутаас 1 цагийн дотор илэрнэ. Энэ шалтгааны улмаас таны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч таныг вакцин хийлгэсэн газартаа богино хугацаанд үлдэхийг хүсэж болно. Хүнд хэлбэрийн харшлын урвалын шинж тэмдэг:

- Амьсгалахад хүндрэлтэй
- Нүүр, хоолой хавагнах
- Зүрх хурдан цохилох
- Бүх биеэр тууралт гарах
- Толгой эргэх ба сульдах

СПАЙКВАКС, Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакцин зэрэг мРНХ КОВИД-19 вакцинууд хийлгэсэн зарим хүмүүс миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардитаар (зүрхний гаднах салст бүрхүүлийн үрэвсэл) өвдсөн. Модерна КОВИД-19 вакцины дараах миокардит болон перикардит нь 18-24 насны эрчүүдэд ихэвчлэн тохиолдсон. Энэ хүмүүсийн ихэнхэд нь вакцин хийлгэснээс хойш хэд хоногийн дотор шинж тэмдэг илэрч эхэлсэн. Ийм тохиолдол үүсэх магадлал маш бага. Хэрэв та болон таны хүүхдэд вакцин хийлгэсний дараа, ялангуяа вакцины нэг тунг хийлгэснээс хойш 2 долоо хоногийн дотор дараах шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрвэл та яаралтай эмнэлгийн тусламж авах хэрэгтэй:

- Цээжээр өвдөх
- Амьсгал давчдах
- Зүрх хурдан, жигд бус, дэлсэх мэдрэмж төрөх

СПАЙКВАКС, Модерна КОВИД-19 вакцин (анхны моновалент), эсвэл Модерна КОВИД-19, Бивалент вакцины клиник тандалтаар дараах гаж нөлөөнүүд мэдээлэгдсэн:

- Тариа хийсэн хэсгийн урвалууд: тариа хийлгэсэн гарын тунгалгийн булчирхай өвдөх, хөндүүрлэх, хавдах, мөн хатуурч хавдах (хатуурах), улайх
- Ерөнхий сөрөг нөлөө: ядрах, толгой өвдөх, булчин өвдөх, үе мөч өвдөх, жихүүдэс хүрэх, дотор муухайрах, бөөлжих, халуурах, тууралт гарах

Мэдээлэгдсэн бусад гаж нөлөө:

- Хүнд хэлбэрийн харшлын урвал
- Чонон хөрвөс (загатнах тууралт/гүвдрүү)
- Миокардит (зүрхний булчингийн үрэвсэл)
- Перикардит (зүрхний гадна талын салст бүрхэвчийн үрэвсэл)
- Вакцин хийлгэсэнтэй холбоотойгоор ухаан алдах

Эдгээр нь СПАЙКВАКС вакцины бүх боломжит гаж нөлөө биш байж магадгүй юм. Танд хамааралтай гаж нөлөөний талаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчээсээ лавлана уу. Та 1-800-822-7967 утас эсвэл <https://vaers.hhs.gov> хаягаар Вакцины сөрөг үр дагаврыг мэдээлэх системд (VAERS) мэдэгдэх боломжтой.

Хэрэв би жирэмсэн эсвэл хөхүүл бол яах вэ?

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ сонголтынхоо тухай ярилцаарай.

Жирэмсний үед бүртгүүлэх боломжтой. Та жирэмсэн болсноо мэдсэн даруйдаа

1-866-MODERNA (1-866-663-3762) утсаар холбогдох эсвэл эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчээсээ бүртгэлийн газартай холбоо барихыг хүснэ үү.

СПАЙКВАКС вакцин ямар найрлагатай вэ?

СПАЙКВАКС вакцин доорх найрлагатай:

- мессенжер рибонуклеины хүчил (mRNA)
- липидүүд (SM-102, полиэтилен гликол [PEG] 2000 димиристойл глицерол [DMG], холестерин, 1,2-дистеароил-сн-глицеро-3-фосфохолин [DSPC])
- трометамин
- трометамин гидрохлорид
- цууны хүчил
- натрийн ацетат тригидрат
- сахароз

СПАЙКВАКС вакцин нөөшлөгч бодис агуулдаггүй.

Хэрэв та нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцах эсвэл www.spikevax.com хаягаар зочлох эсвэл 1-866-MODERNA (1-866-663-3762) руу залгана уу.

Үйлдвэрлэсэн:
Moderna US, Inc.
Princeton, NJ 08540

©2023 ModernaTX, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
СПАЙКВАКС бол ModernaTX, Inc-н худалдааны тэмдэг юм.
Патент(ууд): www.modernatx.com/patents
Хянасан: 2023 оны 9-р сар